

Интернет, хэвлэл мэдээллийн хэрэгсэл өсвөр насны хүүхдийн хүмүүжилд нөлөөлж буй өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл “Интернет, хэвлэл мэдээллийн хэрэгсэл өсвөр насны хүүхдийн хүмүүжилд нөлөөлж буй өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөрийн мэдээлэлтэй танилцаад ЗӨВЛӨМЖ болгох нь:

1. 2014 оны эхний хагас жилд багтаан “Мэдээллийн хэрэгслийн сөрөг нөлөөллөөс хүүхдийг хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого”-ын төсөл, бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, Засгийн газраар батлуулахыг Боловсрол, шинжлэх ухааны яаманд;

2. Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн сөрөг нөлөөллөөс хүүхдийг хамгаалах, хүүхдийн хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүйн яаманд;

3. Хариуцлагатай сэтгүүл зүйг хөгжүүлэх, хэвлэл мэдээллийн бүхий л хэрэгслээр цацаж буй мэдээ мэдээлэл, нэвтрүүлэг, кино, зар сурталчилгаанд насны болон цагийн хязгаар тогтоох олон улсын тэмдэг тэмдэглэгээг хэрэглэж хэвшүүлэхийг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар, Радио телевизийн хэрэг эрхлэх газарт;

4. Цахим тоглоом, цахим үйлчилгээний газрын хууль эрх зүйн орчныг сайжруулах, тэнд үйлчилгээний соёл, стандарт шаардлагыг мөрдүүлэх, цагийн хязгаартай үйлчлэх, 1 хүүхдэд өдөрт үйлчлэх цагийн хязгаарыг тогтоох, сургуулийн орчинд ашиглаж буй интернет орчин дахь хүүхдийн хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлэх агуулгын илэрцийг хянаж, хязгаарлалт хийхийг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа, холбооны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Стандартчилал хэмжил зүйн үндэсний төвд;

5. Хүүхдийг мэдээллийн хэрэгслийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар эцэг эх, иргэдэд сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулахыг төр, олон нийтийн байгууллагуудад;

6. Интернет, хэвлэл мэдээллийн хэрэгслийн сөрөг нөлөөллөөс хүүхдийг урьдчилан сэргийлэх, хамгаалах, байнгын хараа хяналт тавьж ажиллахыг эцэг эх, асран хамгаалагч, хүүхдийн болон иргэний нийгмийн байгууллагуудад;

7. Дээрх асуудалтай холбоотойгоор гарсан хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт шалгалтыг зохих журмын дагуу хийж хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, хуулийн хариуцлага тооцож шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газарт үүрэг болгов.